

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Дашбалбар сумын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2026/001/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn
Чойбалсан хот
2026 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Нармандах
Утас: 7058-4204, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Оюунхэрлэн
Утас: 7058-4207, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4203

2026.03.25 № 425
танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН
ДАШБАЛБАР СУМЫН ЗАСАГ
ДАРГА Н.БАТЗОРИГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Дашбалбар сумын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн нэгтгэсэн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийт хамрах хүрээний байгууллагуудаас илэрсэн алдаа, зөрчлөөс 626.3 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 21.3 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

2126050239

Бусад асуудлын хэсэг

Дашбалбар сумын 2025 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал 86 хувиар дүгнэсэн.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ



Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Дашбалбар сумын 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,175,720.65	2,183,238.99
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,698,669.51	1,582,440.17
3	1.1.3 АВЛАГА	210,050.00	293,366.92
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	267,001.14	307,431.90
5	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	17,223,147.93	18,423,718.86
6	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,223,147.93	18,423,718.86
7	1.2.2.02 Биет хөрөнгө	17,141,274.33	18,342,277.25
8	1.2.2.03 Биет бус хөрөнгө	81,873.60	81,441.61
9	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	19,398,868.58	20,606,957.85
10	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	172.23	59,468.97
11	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	172.23	59,468.97
12	2.1.1.03 Өглөг	172.23	59,468.97
13	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	19,398,696.35	20,547,488.88
14	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	19,398,696.35	20,547,488.88
15	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	885,121.24	811,835.24
16	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	18,147,845.56	19,369,924.09
17	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	365,729.55	365,729.55
18	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	19,398,868.58	20,606,957.85

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	10,305,656.79	10,887,995.13
2	ТАТВАРЫН ОРЛОГО	4,991,124.25	5,435,608.39
3	Орлогын албан татвар	4,278,429.83	4,497,968.26
4	Хувь хүний орлогын албан татвар	4,335,169.27	4,557,968.26
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-56,739.44	-60,000.00
6	Хөрөнгийн албан татвар	571,928.73	747,790.09
7	Бусад татвар, төлбөр, хураамж	140,765.69	189,850.04
8	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,274,243.54	5,452,386.74
9	Тусламжийн орлого	500,000.00	508,260.80
10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,040,289.00	0.00
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,103,655.56	7,475,918.64
12	УРСГАЛ ЗАРДАЛ	5,103,655.56	6,152,275.46
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,970,903.95	3,736,199.46
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	692,676.33	843,141.73
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,145.52	102,518.03
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	573,284.91	691,924.32
17	Хангамж, бараа материалын зардал	59,732.47	60,024.68
18	Нормативт зардал	0.00	350.00
19	Эд хогшил, урсгал засварын зардал	37,482.06	44,959.78
20	Томилот, зочны зардал	21,084.50	18,696.11
21	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	163,371.78	323,444.52
22	ХҮҮ		136,000.00
23	Бараа үйлчилгээний бусад зардал	1,343,126.38	1,515,140.29
24	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,132,751.61	2,416,076.00
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	5,202,001.23	3,412,076.49
26	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	1,323,643.18
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,805,454.26	2373509.12
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-2,805,454.26	-2,373,509.12
29	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	2,396,546.97	1,038,567.37

Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Дашбалбар сумын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,932,917.77	16,932,917.77
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	- 3,373,355.26	- 3,373,355.26
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,559,562.51	13,559,562.51
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	3,369,300.87	3,369,300.87
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	73,286.00	73,286.00
6	Тайлант үеийн үр дүн	2,396,546.97	2,396,546.97
7	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,398,696.35	19,398,696.35
8	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	19,398,696.35	19,398,696.35
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	- 3,259,075.71	- 3,259,075.71
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,139,620.64	16,139,620.64
11	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	3,369,300.87	3,369,300.87
12	Тайлант үеийн үр дүн	1,038,567.37	1,038,567.37
13	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	20,547,488.88	20,547,488.88

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	8,157,668.05	8,971,120.41
2	ТАТВАРЫН ОРЛОГО	4,991,124.25	5,435,608.38
3	Орлогын албан татвар	4,278,429.83	4,497,968.26
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	- 56,739.44	- 60,000.00
5	Хөрөнгийн албан татвар	571,928.73	747,790.09
6	Бусад татвар, төлбөр, хураамж	140,765.69	189,850.04
7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,522.01	3,820.50
8	Газрын төлбөр	80,243.68	126,532.09
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	5,400.00	59,497.46
10	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,126,254.79	3,535,512.03
11	Нийтлэг татварын бус орлого	1,626,254.79	2,195,051.08
12	Тусламжийн орлого	500,000.00	508,260.81
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	832,200.14
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,040,289.00	
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,482,311.78	5,239,770.18
16	УРСГАЛ ЗАРДАЛ	4,482,311.78	5,239,770.18
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,349,560.16	2,823,694.18
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	787,024.21	1,023,489.29
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,539.04	102,518.03
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	590,678.43	708,133.55
21	Хангамж, бараа материалын зардал	93,037.00	109,237.60
22	Нормативт зардал	1,204.50	350.00
23	Эд хогшил, урсгал засварын зардал	46,701.40	47,039.78
24	Томилолт, зочны зардал	21,084.50	18,696.11
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,945.13	54,088.87
26	Бараа үйлчилгээний бусад зардал	681,345.96	760,140.95
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,132,751.61	2,416,076.00
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	3,675,356.27	373,135,023.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН		8.68
29	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	2,862,117.93	3,711,588.24
30	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,862,117.93	3,711,588.24
31	Дотоод эх үүсвэрээр	2,862,117.93	3,711,588.24
32	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	- 2,862,117.93	- 3,711,579.57
33	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		136,000.00
34	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		- 136,000.00
35	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	813,238.34	- 116,229.34
36	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	885,431.17	1,698,669.55
37	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,698,669.51	1,582,440.17

**Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Дашбалбар сумын 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,430,950.60	8,693,444.93	(1,737,505.67)	83.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,430,950.60	8,693,444.93	(1,737,505.67)	83.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,018,092.50	2,503,632.57	(514,459.93)	82.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	997,831.20	848,201.65	(149,629.55)	85.00
210101	Үндсэн цалин	507,603.20	478,450.23	(29,152.97)	94.26
210102	Нэмэгдэл	413,629.90	312,884.37	(100,745.53)	75.64
210104	Урамшуулал	76,598.10	56,867.05	(19,731.05)	74.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	125,353.80	102,518.02	(22,835.78)	81.78
210201	Тэтгэврийн даатгал	85,240.60	70,698.59	(14,542.01)	82.94
210202	Тэтгэмжийн даатгал	10,028.30	8,601.11	(1,427.19)	85.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,014.10	4,189.37	(824.74)	83.55
210204	Ажилгүйдлийн даатгал	5,014.10	3,807.70	(1,206.40)	75.94
210205	Эрүүл мэндийн даатгал	20,056.70	15,221.26	(4,835.44)	75.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	781,602.00	691,924.32	(89,677.68)	88.53
210301	Гэрэл, цахилгаан	66,212.30	47,679.36	(18,532.94)	72.01
210302	Түлш, халаалт	661,043.50	614,530.16	(46,513.34)	92.96
210303	Цэвэр, бохир ус	54,346.20	29,714.80	(24,631.40)	54.68
2104	Хангамж, бараа материалын зардал	44,596.70	37,275.76	(7,320.94)	83.58
210401	Бичиг хэрэг	5,003.80	4,304.10	(699.70)	86.02
210402	Тээвэр, шатахуун	23,957.50	20,141.87	(3,815.63)	84.07
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,966.70	6,787.85	(1,178.85)	85.20
210405	ариутгал	475.90	-	(475.90)	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,192.80	6,041.94	(1,150.86)	84.00
2105	Нормативт зардал	1,401.40	350.00	(1,051.40)	24.98
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,401.40	350.00	(1,051.40)	24.98
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,020.10	47,039.78	(1,980.32)	95.96
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,624.90	4,330.00	(294.90)	93.62
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	532.30	160.00	(372.30)	30.06
210604	Урсгал засвар	43,862.90	42,549.78	(1,313.12)	97.01
2107	Томилолт, зочны зардал	24,194.20	17,740.00	(6,454.20)	73.32
210702	Дотоод албан томилолт	24,194.20	17,740.00	(6,454.20)	73.32
2108	хураамж	9,300.10	881.50	(8,418.60)	9.48
210801	үйлчилгээний төлбөр хураамж	4,702.20	245.00	(4,457.20)	5.21
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,296.00	-	(1,296.00)	-
210803	Даатгалын үйлчилгээ	473.60	-	(473.60)	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	363.20	196.50	(166.70)	54.10
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	156.40	-	(156.40)	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,635.50	440.00	(1,195.50)	26.90
210807	Газрын төлбөр	673.20	-	(673.20)	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	984,793.00	757,701.55	(227,091.45)	76.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	978,200.60	752,651.55	(225,549.05)	76.94
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,592.40	5,050.00	(1,542.40)	76.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,420,247.80	2,416,076.00	(4,171.80)	99.83
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,402,684.90	2,402,684.90	-	100.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,402,684.90	2,402,684.90	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,562.90	13,391.10	(4,171.80)	76.25
213208	албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,520.00	12,051.99	(2,468.01)	83.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,042.90	1,339.11	(1,703.79)	44.01

Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Дашбалбар сумын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,781,920.80	3,637,736.36	(1,144,184.44)	76.07
223001	Бусад хөрөнгө	4,781,920.80	3,637,736.36	(1,144,184.44)	76.07
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	210,689.50	136,000.00	(74,689.50)	64.55
230001	Эргэж төлөгдөх зээл	210,689.50	136,000.00	(74,689.50)	64.55
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,430,950.60	8,700,963.27	(1,729,987.33)	83.41
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,428,565.81	8,699,963.27	271,397.46	103.22
132001	Орон нутгийн төсвөөс	7,075,027.21	7,367,763.13	292,735.92	104.14
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	1,353,538.60	1,332,200.14	(21,338.47)	98.42
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,002,384.79	1,000.00	(2,001,384.79)	0.05
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000.00	1,000.00	-	100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	0.00	-	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,001,384.79	-	(2,001,384.79)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,175,720.65	2,175,720.65	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,183,238.99	2,183,238.99	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦЭВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	158,115.30	5,690.81
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,410.14	5,690.81
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	139,705.16	
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	158,115.30	5,690.81
2104	Хангамж, бараа материалын зардал	13,529.90	
210402	Тээвэр, шатахуун		3,584.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		150.00
2107	Томилолт, зочны зардал	4,004.50	956.11
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	140,580.90	1,000.00

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2 зөрчил¹ илэрсэнд 1 албан шаардлага 2 зөвлөмж хүргүүлсэн.

Нийт хамрах хүрээний байгууллагуудаас илэрсэн алдаа, зөрчлөөс 626.3 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

Шилэн дансны цахим системд орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төслийг байршуулаагүй, хагас жилийн санхүүгийн тайлан, батлагдсан төсвийг хугацаа хоцроож байршуулсан. Шилэн дансны тухай хуулийн 6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ: 6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор; 6.1.3.дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор; 6.1.4.жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор; гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн орлого төлөвлөгөөний биелэлттэй холбоотой.

Илрүүлэлт: Тайлант оны сумын төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр давж биелсэн ч цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 210.3 сая, улсын тэмдэгтийн хураамж 3.5 сая, ус, рашааны нөөц ашигласны төлбөр 5.3 сая, хог хаягдлын үйлчилгээний хураамж 3.2 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь бүрэн төвлөрүүлж ажиллах

2. Худалдан авах ажиллагаатай холбоотой.

Илрүүлэлт: Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд тендерт шалгарсан гүйцэтгэгч, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, гэрээ хүлээлцсэн акт зэргийг мэдээлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.5-д "тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр цахим системд нийтлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд тендерт шалгарсан гүйцэтгэгч, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, гэрээ хүлээлцсэн актыг байршуулж байх

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлогын төлөвлөгөө нэр төрлөөрөө тасарсан	1	-					1	-
Тендерт шалгарсан гүйцэтгэгч, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, гэрээ хүлээлцсэн акт зэргийг мэдээлээгүй.	1	-					1	-
Нийт дүн	1	-					1	-

**Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Дашбалбар сумын 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар										
Шилэн дансны цахим системд орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төслийг байршуулаагүй, хагас жилийн санхүүгийн тайлан, батлагдсан төсвийг хугацаа хоцроож байршуулсан.	1	-			1	-				
Дүн	1	-			1	-				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс таггалсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1				1		
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			